



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/322

Арвайхээр

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа,  
стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх,  
тохирлын гэрчилгээжүүлэх ажлыг зохион  
байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 16 дугаар зүйлийн 16.4.1 дэх заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.2 дугаар заалт, Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”, Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.5.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, хүүхэд хөгжлийн “Цагаан залаа” зуслангийн үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийх, шалган туслах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнгийн тайланг 2022 оны 06 дугаар сарын 28-ны дотор албан бичгээр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн (Г.Даариймаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

6222 11 0693

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны  
...дугаар сарын ...-ны өдрийн  
...дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Г.Даариймаа (аймгийн Засаг даргын дэргэдэх  
Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Бүтээгдэхүүн  
баталгаажуулалтын мэргэжилтэн)

Гишүүд:

Х.Гэрэлмаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл,  
хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрх,  
хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн, Хүүхдийн  
эрхийн улсын байцаагч)

Д.Мөнхтуяа (аймгийн Засаг даргын дэргэдэх  
Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар  
стандартын хяналтын улсын байцаагч)

А.Балжинням (аймгийн Онцгой байдлын газрын  
Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч  
ахмад)

Ц.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс,  
хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, худалдаа  
үйлчилгээний албаны дарга)

Д.Доржгаваа (аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн  
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Ц.Эрхномуун (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл  
мэндийн газрын Халдварт өвчин, бэлгийн зам,  
эмнэлгээс шалтгаалах, цусаар дамжих болон  
гэдэсний халдварын тандалт сэргийлэлт,  
хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан  
мэргэжилтэн)

Ажлын хэсгийн нарийн бичиг: С.Пагамцогсмаа (аймгийн Засаг даргын  
дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтсийн  
Бүтээгдэхүүн баталгаажуулалтын  
мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2022 оны  
06 дугаар сарын 22-ны өдрийн  
А.332 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт

## УДИРДАМЖ

Хүүхэд хөгжлийн “Цагаан залаа” зуслангийн үйл ажиллагаанд  
тохирлын үнэлгээ хийх, шалган туслах ажлаар  
ажиллах тухай

### Зорилго:

Хүүхэд хөгжлийн “Цагаан залаа” зуслангийн үйл ажиллагаа, хүүхэд хүлээж авах бэлтгэл ажлыг шалгаж, “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага MNS 5633:2019 стандарт”-ын хэрэгжилтэнд тохирлын үнэлгээ хийх, гэрчилгээжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх

### Хугацаа:

2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

### Гүйцэтгэх үйл ажиллагаа:

Мэргэжлийн байгууллагын чиг үүрэг бүхий мэргэжилтнүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр хяналт, шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгнө.

Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр мөрдөгдөж байгаа Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийнэ.

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг тохирлын үнэлгээний шалгах асуумжийн дагуу үнэлж, дүгнэлт гаргана.

Хяналт шалгалтаар зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.

### Үр дүн:

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын шаардлага хангагдаж, хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа сайжирснаар хүүхдийн эрхийн зөрчил буурч, хүүхэд хамгаалал сайжирч, хүүхдүүд ая тухтай амарна. Хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагаа, уялдаа холбоо сайжирна.

### Тайлагналт:

Ажлын тайланг 2022 оны 06 дугаар сарын 28-ны дотор албан бичгээр танилцуулж, гарсан зөрчил дутагдлын мөрөөр хугацаатай үүрэг даалгавар өгч, хяналт тавьж ажиллах.